

ГАДААД ХЭЛ ЗААХ АРГАД ХОЛБОГДОХ ХЭЛШИНЖЛЭЛИЙН ЗАРИМ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Л.Маналжав, Sc.D, профессор

Хэл шинжлэлчид онолын бүтээлүүддээ гадаад хэл заах аргын асуудлыг хөндөх болсон нь орчин цагийн хэл шинжлэлийн ухааны нэгэн шинэлэг зүйл. Тэдний дотроос олон бүтээлтэй, хэл шинжлэлд “хувьсгал” гаргасан гэж тооцогддог Америкийн нэрт хэл шинжлэлч Н.Чомскийн үзэл баримтлал сонирхол татдаг билээ. Хэл, сэтгэхүй хоёрын холбооноос үүдэн нийт хүн төрөлхтний олон хэлэнд түгээмэл хууль үйлчилдэг гэж үздэг. Ямар хэлээр ярьж байгаагаас үл шалтгаалан хүмүүсийн мэдрэхүй, сэтгэл хөдлөл, ойлголт бараг адил байдаг учраас нэгэн ертөнцөд амьдарч байгаа хүн төрөлхтний хэлний зүй тогтол, хэлзүйн дүрэмд түгээмэл зүйл байна гэсэн санаа түүний энэхүү үзэл баримтлалын цөм нь юм. Н.Чомскийн “Түгээмэл хэл зүй” (Universal grammar)-н онолын чухал нэг хэсэг нь гадаад хэл заах аргатай шууд холбоотой. Энэхүү өгүүлэлд түүний дээрх үзэл баримтлалыг тайлбарлахыг оролдлоо.

Өнгөрсөн зууны тавиад оны дунд үеэс Америкийн хэл шинжлэлд гарч ирсэн үүсгүүр хэлшинжлэл (generative linguistics)-ийн гол төлөөлөгч Н.Чомскийн дэвшүүлсэн хэлийг загварчлах шинэ үзэл баримтлалыг дэмжигчид ч, эсэргүүцэгчид ч олон байдаг. Харин түүний бүтээлийн гадаад хэл заах аргатай холбоотой хэсэг нь одоо өрнөдийн гадаад хэл, ялангуяа англи хэл заах коммунатив аргын үндэс болж өгч байна.

Төрөлх хэл, гадаад хэлний уялдаа холбоо, ялгаа

Н.Чомский юуны өмнө нэгдүгээр хэл буюу төрөлх хэл, хоёрдугаар хэл буюу гадаад хэл гэж эдгээрийн хоорондын уялдаа холбоо, нэг хоёрдугаар хэлийг сурахад ямар ялгаатай болох талаар өгүүлээд S_0 (S гэдэг нь state- байдал гэсэн үг) байдлаас эхэлж, хэлийг бүрэн эзэмшин бэхжиж тогтсон S_s (S_s гэдэг нь stable state- тогтворжсон гэсэн үг) байдалд хүрдэг байна. S_0 - S_s хүрэх явцад төрөлх хэлнийхээ талаар бүх талын тогтсон мэдлэгтэй болно.

Хоёрдугаар хэл буюу гадаад хэлийг сурч байгаа хүмүүс бол нэгэнт нэг хэлийг эзэмшсэн байна. Төрөлх хэлээ мэднэ гэдэг бол түгээмэл хэлзүйг аяндаа эзэмшсэн байна гэсэн үг. Гэхдээ гадаад хэлийг сурч байгаа хүмүүс төрөлх хэлээ бүрэн төгс тогтож бэхжсэн байдал хүртэл эзэмшээгүй байхыг бас үгүйсгэхгүй.

Ихэнх тохиолдолд хүмүүс гадаад хэлийг сурахдаа төрөлх хэлийг сурахаас үр дүн муутай

байдаг. Насанд хүрсэн хүн төрөлх хэлээ сурахдаа S_s байдалд хүрэхдээ тун бэрхшээлтэй байдаг. Ийм учраас нэгдүгээр хэл, хоёрдугаар хэлийг сурч эзэмших байдлыг ялгаатай томъёолох нь зүйтэй юм.

/Төрөлх хэл/ Хэл₁ сурахад S_0 S_s
(0 байдлаас тогтворжсон байдалд хүрнэ)

/Гадаад хэл/ Хэл₂ сурахад S_1 S_t
(гарааны байдлаас тодорхой цэгт хүрнэ)
(1гэдэг нь initial-гарааны байдал, t-terminal-хүрэх цэг)

ТХЗ-ын (UG)-ын зарчмыг гадаад хэл заахад хэрэглэх нь:

Нэгдүгээр хэл буюу төрөлх хэлийг сурахад сэтгэхүйн төрөлх шинж чанартай (inherent properties) холбоотой мэдлэг гэж тайлбарласан байдаг бол, гадаад хэлийг сурахад S_1 эцсийн шатандаа S_t байдалтай байдаг нь төрөлх хэлнээс ялгаатай байдгийг харуулж байна. Ийнхүү Н.Чомскийн онолоор гадаад хэл заах гурван загвар байж болох байна. Энд түгээмэл хэлзүйн үүрэг ямар байх вэ? Дээр дурьдсан гурван загварыг түгээмэл хэлзүйтэй холбон авч үзвэл нэгдүгээрт гадаад хэлийг заахдаа шинэ гараанаас эхэлж, түгээмэл хэлзүйд хүртэй, төрөлх хэлний нөлөө үгүй байна. Хоёрдугаарт гадаад хэлийг сурахдаа төрөлх хэлийг сурсантай адил төстэй, төрөлх хэлийг сурсан мэдлэгээрээ дамжуулан түгээмэл хэлзүйд шууд бус хүртэй байх, гуравдугаар тохиолдолд гадаад хэлийг сурахдаа түгээмэл хэлзүйг огт хайхрахгүй түүнд хүртгүй, түүнийг огт хэрэгсэхгүйгээр сургах. Эдгээр аргыг тус бүрт нь авч үзье.


Түгээмэл хэлзүйд шууд хүртэй

Гадаад хэлийг заахдаа (Н.Чомскийн онолоор) төрөлх хэлний хэлзүйд түшиглэхгүйгээр, түгээмэл хэлзүйн зарчим, хэмжээсүүдийг хэрэглэх

Түгээмэл хэлзүй


Түгээмэл хэлзүйд шууд бус хүрцтэй

Гадаад хэлийг заахдаа төрөлх хэлийг сурахдаа эзэмшсэн түгээмэл хэлзүйг дамжих шат мэт ашиглаж, сурах гадаад хэлнийхээ зарчим хэмжээсүүдийг эзэмшинэ.



Түгээмэл хэлзүйд хүрцгүй

Гадаад хэлийг ердийн бус (non natural) аргаар сурч болно. Энэхүү загварт гадаад хэлний чадавхи нь төрөлх хэлнээс тусдаа байна.



Гадаад хэлийг сурахдаа ердийн бус аргаар мөн сурч болно. Сүүлийн өгүүлж байгаа загварт гадаад хэлний чадавхи нь төрөлх хэлнээс ялгаатай. Гадаад хэлийг сурахдаа төрөлх хэлийг сурахад эзэмшсэн түгээмэл хэлзүйг анхааралдаа авалгүй тухайн гадаад хэлийг хэлзүйн номоор сургах, эсвэл шууд дууриаж сургадаг.

Эдгээр гурван загварыг сонгон авсан тухайд гэвэл, аль алиныг нь хэрэглэж болох талтай. Тэр ч бүү хэл нэг хүний хувьд тухайн хэлний өөр өөр талыг сурахад аль нэгийг нь хэрэглэж болно. Гадаад хэлийг сурахад сурч байгаа хувь хүн, нөхцөл байдал хоёрын харилцан үйлдлээс шалтгаалан аль алиныг нь баримтлагчид, хамгаалагчид бий. Энэ гурван загварыг бидний нэрлэж заншсан гадаад хэл, заах аргуудтай холбон тодруулж хэлбэл орчуулгын арга гэдэг нь гадаад хэлийг заахдаа төрөлх хэлрүүгээ хандаж байдаг шууд бус аргыг хэлдэг байна. Коммуникатив хандлага буюу шууд арга гэдэг нь сонгон авсан гадаад хэлэндээ тулгуурладаг арга юм. Түгээмэл хэлзүйд хүрцэхүй арга нь сэтгэхүйн бусад шинж чанаруудыг ашигладаг хэлзүйг тайлбарлан заах аргыг хэлнэ.

Гадаад хэлний багш нар эдгээр аргуудын алиныг ч хэрэглэж сургалтыг амжилттай

хэрэгжүүлж болно гэж үздэг. Гагцхүү аль нь илүү амжилттай, үр өгөөжтэй эсвэл үр өгөөж муутай гэдэгт хэргийн учир оршино. Эдгээр загваруудын алиныг нь ч хэрэглэж болох талтай. Харин түгээмэл хэлзүйд хүрцгүй загварыг хойш тавих нь зүйтэй болов уу гэсэн саналтай байна. Учир нь хэлний чадавхи нь оюун ухааны бусад чадавхиас ялгаатай боловч энэхүү загварт зөвхөн тэдгээртэй холбоотой байхыг шаарддаг. Нөгөө хоёр загварын хувьд түгээмэл хэлзүйтэй холбоотой. Магадгүй зарим эх үүсвэр нь хаанаас гаралтайг өөрөө мэдэхгүйгээр түгээмэл хэлзүйн зарчмыг хэрэглэж байгаа байж болзошгүй.

Судалгаанд шууд бус аргыг зөв гэж санал болгодог бөгөөд хоёрдугаар хэл буюу гадаад хэлийг заахдаа төрөлх хэлтэйгээ хамт эзэмшсэн түгээмэл хэлзүйг төрөлх хэлний S_t буюу гадаад хэлийг эзэмших эхний шатанд хүрэх дамжуурга болгон хэрэглэдэг. Гэхдээ төрөлх хэлээ эзэмшсэн тэр мэдлэг нь өөр бүтэцтэй хэлүүдийг эзэмшихэд хөтөч болж чадахгүй. Яагаад гэвэл тэдгээр хүмүүсийн сэтгэхүй, оюун ухаанд байгаа түгээмэл хэлзүй нь хэлүүдийн ялгаа, хязгаарлалыг зааж өгөх ёстой.

Суралцагчдын ялгааг үл харгалзан загваруудыг хооронд нь тодорхой зааглах нь дээр гэж үздэг хүмүүс бий. Гэвч энэ загвар тодорхой хүрээний суралцагчдад тохирох талтай. Жишээлбэл: хэлзүй, орчуулгын (grammar-translation method) арга нь өндөр боловсролтой (high academic calibre) хүмүүст заахад илүү амжилтанд хүрэх, эсвэл түгээмэл хэлзүйд хүрцгүй загвар нь боловсролтой, бичгийн чадвар сайтай хүмүүст тохирох жишээтэй.

Энд хэл сурахад хүний насны асуудал хэр зэрэг үүрэгтэй талаар хэлшинжлэлчид ямар үзэл бодолтой байдаг тухай товч дурдая. Гадаад хэлийг ямар ч насанд сурч болно. Гэхдээ гадаад хэлийг сурахдаа аль ч тохиолдолд төрөлх хэлнээсээ хожуу сурч эхэлдэг. Хүүхэд гадаад хэлийг амархан сурдаг гэж нийтээр үздэг, насанд хүрсэн хүмүүсийн аялга заавал үлддэг. (1967) “Заагт үе шатны тухай таамаглал”-даа (Critical Period Hypothesis) насны ялгааны талаар тайлбарлаж, хэлэх, сурах чадвар нь арван хэдэн насандаа үгүй болдог, түгээмэл хэлзүй нь насанд хүрсэн тодорхой цэгт хүрмэгц үйлчлэхээ зогсдог гэжээ.

Lenneberg гадаад хэлийг төрөлх хэлээр дамжуулж сурсан нь дээр гэж үзэж, СРН нь суралцагчийн наснаас шалтгаална гээд, шууд аргыг арван хэдэн нас хүртэл, шууд бус аргыг түүнээс хойш хэрэглэж болно гэсэн байна. Гэтэл Krashen үүний бараг эсрэг саналтай, шууд аргыг

хэзээ ч хэрэглэж болно, харин түгээмэл хэлзүйд хүрцгүй загварыг 20 нас дөхүүлж байж хэрэглэх нь зүйтэй гэжээ.

Н.Чомский энэ тухайд нэг хэлийг эзэмших боломжтой байгаа бол бусад хэлүүдийг эзэмшихэд харьцангуй амар гэж үздэг.

Ийнхүү хэлийг эзэмших, цааш нь яаж хөгжүүлэх тухай асуудал бол төрөлх хэл болон гадаад хэлийг сурахад чухал ач холбогдолтой. Төрөлх хэлний хөгжил нь хүлээн авах, танин мэдэх чадавхийн хөгжилтэй зэрэгцэн явдаг. Гадаад хэлнийх бол ялгаатай, танин мэдэхүйн (когнитив) процесс нь хоёр дахь хэлэнд шууд шилжиж байна гэж хэлж болохгүй. Гадаад хэлний мэдлэгийг хөгжүүлэхэд хэлний бус чадавхиуд нь хэлний мэдлэгтэй зэрэгцэн явдаггүй, автомат маягтай, хязгаарлагдмал байдалтай. Түгээмэл хэлзүй нь төрөлх болон гадаад хоёр хэлний зарчмууд, хэмжээсүүд нэгэн зэрэг нэгэн оюун ухаанд хэрхэн хамаарагддагт тайлбар өгөх ёстой хэлшинжлэлийн онол гэж орчин үеийн хэл шинжлэлч, сэтгэл судлаач нар үзэж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. N.Chomsky, Aspects of the Theory of Syntax, 1965, Cambridge, Mass.: MIT Press
2. N.Chomsky, Principles and parameters in syntactic theory. In N.Hornstein and D.Lightfoot (eds), Explanations in Linguistics, London, 1981, Longman
3. N.Chomsky, Some concepts and consequences of the Government and Building, Cambridge, Mass. MIT Press
4. N.Chomsky, Knowledge of Language: It's nature, origin and use, New York, Praeger
5. V.J.Cook, Chomsky's Universal grammar, an Introduction, 1989, Basil Blackwell, Oxford

Гадаад хэлний боловсрол. 2002. №1